

МОНГОЛ ГАРАЛ ҮҮСЭЛТЭНГҮҮДИЙН ДЭЛХИЙН АНХДУГААР ХУРАЛ БОЛЛОО

Улаанбаатар хотноо байрладаг Дэлхийн Монгол гарал үүсэлтэнгүүдийн төвийн дарга доктор О.Нямдаваагийн санаачилгаар, Холбооны Ардчилсан Бүгд Найрамдах Балба Улсын “Жинхэнэ Монголчуудын Бүгд Найрамдах Форм”-ын дарга Кумар Фудонг Монгол гарал үүсэлтэнгүүдийн анхдугаар чуулганыг 2013 оны 4 дүгээр сарын 5 ны өдөр Катманду хотод зохион байгуулав.

Хуралд Энэтхэгийн Монгол гарал үүсэлтэнгүүдийг төлөөлж парламентын гишүүн Сансума тэргүүнтэй төлөөлөгчид, Балбын 12 гол Монгол аймгийн төлөөлөл, Улаанбаатараас 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид, Монгол Улсын өргөмжит консул ноён Цэдэн Журме Шреста нар тус тус оролцов. Хуралд хүрэлцэн ирж чадаагүй Мянмар, Солонгос, Хазарачуудын төлөөлөгчид илгээлт ирүүлж амжилт хүсэв. Монгол Улсын их хурлын гишүүн С.Ганбаатарын илгээлтийг хуралд оролцогчдод О.Нямдаваа уншиж танилцуулав.

Хуралд оролцсон төлөөлөгчдөд Монголын соёл зан заншил, түүхийг харуулсан баримтат кино тухайлбал Торго салоны үзүүлбэрүүд, уртын дуу морин хуурын тоглолтыг сонирхуулж, дэлхийн Монгол гарал үүсэлтэнгүүдийн талаар бичсэн номынхоо талаар болон Монголын соёл зан заншилтай ижил төсөөтэй зүйлийн талаар др. О.Нямдаваа илтгэл тавив.

Др.Кумар Фудонг Балбын Монгол гаралтай хүмүүсийн талаар, Энэтхэгийн парламентын гишүүн Сансума Энэтхэгийн Монгол гаралтай хүмүүс тэдний дотроос Боро ястны талаар, Цэдэн Журме Монгол-Балбын хамтын ажиллагааны талаар тус тус илтгэл тавив.

Хурлаас Монгол Улсын нийслэл Улаанбаатарт хандаж уриалга гаргасныг хавсаргав. Хурлын эцэст хэвлэлийн бага хурал хийж, үр дүнгийн талаар хэвлэлийнхэнд мэдээлэл хийв. Дараачийн хурлыг 2014 онд Энэтхэгт, 2015 онд Улаанбаатарт тус тус хийхээр тохиролцов.

Монгол Улсын нийслэл Улаанбаатарт хандсан уриалга

1. Дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй олон сая Монгол болон Монгол гарал үүсэлтэн- бид Монголын нийслэл Улаанбаатарыг өөрийн өмөг түшиг, Монгол хэл соёл, зан заншилын дэлгэрүүлэгч

Олон улс судлал

төв хэмээн үзэж, бидний очиж үзэх ёстой өвөг дээдсийн ариун шүтээн нутаг хэмээн мөрөөдөж байдаг.

2. Монгол гарал үүсэлтэн бидэнд Монголд суралцах байнгын цалин олгож байх,

3. Монгол гарал үүсэлтэний дунд Монгол соёл, зан заншил түгээн дэлгэрүүлж, бидний бишрэн хүндэлдэг, мянганы хүн Чингис хаан болон эртний Монгол түүх шастирыг нягтлах судлах ажлыг дэмжих,

4. Монгол гарал үүсэлтэн бидний амьдарч буй орнуудад болон тэднийг хамарсан бүсчилсэн Монгол соёлын төвийг байгуулах,

5. Катманду хотод жил бүр зохион байгуулдаг “Мисс Монгол” тэмцээнд Монгол охидын төлөөлөл оролцуулах,

6. Дэлхийд тархсан Монгол гарал үүсэлтэй бидний хэл, соёл, зан заншил, уламжлалаа хадгалах, хамгаалах, хөгжүүлэхэд үлгэрчлэн дэмжлэг үзүүлэх,

7. Монгол гарал үүсэлтэй иргэдийн олон улсын хоёрдугаар бага хурлыг 2014 онд БНЭУ-ын нийслэл Шинэ Делид, гуравдугаар хурлыг 2015 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тус тус зохион байгуулагдахад туслахыг уриалж байна.

Монгол гарал үүсэлтэй иргэдийн олон улсын анхдугаар бага хуралд оролцогчид, Балбын нийслэл Катманду хот, 2013 оны 4 дүгээр сарын 5.

Мэдээ бэлтгэсэн О.Нямдаваа